



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 13 өдөр

Дугаар 01295

Улаанбаатар хот

Хүүхэд, залуучуудын сургалт
хүмүүжлийн тусгай цогцолборын
данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 3,149,900.0 /гурван сая нэг зуун дөчин есөн мянга есөн зуун/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Хүүхэд, залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор /Б.Лхамсүрэн/-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хүүхэд, залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор /Б.Лхамсүрэн/-т үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2019 оны 08 сарын
 13 өдрийн 028 дугаар тушаалын хавсралт



Бүртгэлд авах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Хүүхэд, залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт, хүчин чадал	Ашиглалтанд орсон	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ		Хандивлагч байгууллага	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
Машин, тоног төхөөрөмж											
1	Даралтат хөгжим	Yamaha		2019	Сайн	ш	1	2,249,900.00	2,249,900.00	Япон улсын иргэн Ямашита	Хандив
2	Бөмбөр	Yamaha		2017	Сайн	ш	1	300,000.00	300,000.00	Иргэд	Хандив
3	Өнгөт принтер	Epson	3 үйлдэлтэй, өнгөт	2018	Сайн	ш	1	600,000.00	600,000.00	JCI олон улсын байгууллага	Хандив
Машин, тоног төхөөрөмжийн дүн									3,149,900.00		
Нийт хөрөнгийн дүн									3,149,900.00		